

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн талаарх танилцуулга

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7-д заасны дагуу Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс хойш 60 хоногийн дотор багтаан мөрийн хөтөлбөрөө боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэгтэй билээ.

Монгол улсын Ерөнхий сайдын 2008 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 02 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг (ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан Ерөнхий сайдын захирамжийг хавсаргав) Үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг ажлын 15 хоногт багтаан боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж байна. Төслийг боловсруулах явцдаа хөтөлбөрийн зорилтууд болон хүрэх үр дүнгийн төслийн талаар яамд тус бүрээс дахин саналыг авч, төслийг нягтлан үзсэн болно.

Хөтөлбөрийг боловсруулахдаа УИХ-ын 2008 оны 12 тоот тогтоолоор батлагдсан Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан Үндэсний хөгжлийн цогц бодлого, МАХН, Ардчилсан намын хооронд 2008 оны 9 дүгээр сарын 12-ний өдөр байгуулсан хамтын ажиллагааны гэрээ болон хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөллийн санал, Монгол улсын Засгийн газраас олон улсын байгууллагуудтай өмнөх жилүүдэд байгуулсан гэрээ, хэлэлцээр зэргийг үндэслэн боловсруулав.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь улс орны нийгэм, эдийн засаг, улс төр, байгаль орчин, бүс нутгийн хөгжил болон нийгмийн бүхий л бүлэг давхаргын асуудлыг хамарсан байх шаардлагатай бөгөөд энэхүү шаардлагад нийцүүлэн хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмд настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөдөлмөр эрхлэгчид зэрэг нийгмийн бүхий л давхарга, хүрээний өмнө тавигдаж байгаа зорилтыг өргөн хүрээгээр хамруулан тусгахыг эрмэлзсэн болно.

Энэ удаагийн боловсруулсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн нэг үндсэн онцлог бол зөвхөн өөрийн эх орондоо оршин сууж байгаа Монгол улсын иргэдийн нийгэм, эдийн засгийн асуудлаас гадна анх удаа хилийн чанадад, гадаад оронд оршин сууж, ажиллаж, сурч, хөдөлмөрлөж, амьдарч байгаа иргэдийнхээ өмнө тулгамдаж байгаа олон асуудлыг шийдвэрлэх, зохицуулах талаарх зорилтыг тусгаснаар онцлог болсон.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн онцлогууд нь:

- Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд, хүрэх үр дүнг тодорхойлон тусгасан,
- Засгийн газрын бодлогын зорилтууд болон зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг зааглан, ялгахыг эрмэлзсэн,

- Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үндсэн арга зам, арга хэрэгслүүд, хэрэгжилтийн явцад учирч болох эрсдэлийг тооцсон,
- Тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг урьдчилсан байдлаар тооцож тусгасан,
- Хувийн хэвшлийнхний ирэх жилүүдэд хэрэгжүүлэхээр тооцсон зорилтууд, Засгийн газрын зүгээс Олон улсын байгууллагууд, гадаад орнуудтай хамтын ажиллагааны чиглэлээр өмнө байгуулсан гэрээ, төсөл, хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээг уялдуулах, эдгээрийн хооронд холбоос тогтоох оролдлогыг хийсэн болно.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа Засгийн газрын залгамж чанарыг хадгалж, өмнөх жилүүдэд УИХ, Засгийн газраас баримталж ирсэн бодлого, баталсан хөтөлбөр, стратегийн баримт бичиг, гэрээ, хэлэлцээрүүдэд тусгагдсан үндсэн зорилт, бодлогыг үргэлжлүүлэхийн хамт өөрчлөгдөж байгаа дэлхий ертөнц, олон улсын эдийн засаг, санхүүгийн байдал, байгаль цаг уурын өөрчлөлт зэрэгтэй уялдуулан улс орны нийгэм, эдийн засаг, байгаль орчны бодлогод тодорхой хэмжээний өөрчлөлт шинэчлэлт, шинэ хандлага шаардлагатай гэж үзэж, хөгжлийн тодорхой зорилт, арга замыг шинээр боловсруулан тусгалаа. Тухайлбал Монгол улс 1990-ээд оноос хойш зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжихээр зорьж хөгжиж ирсэн боловч өнөөг хүртэл зах зээлийн эдийн засгийн гол тулгуур болох учиртай үндсэн суурь зах зээлийн тогтолцоог зохих зарчмын дагуу зөв зохистой бүрдүүлээгүйн улмаас хүнсний хомсдол, үнийн өсөлт, ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгэм, эдийн засгийн тулгамдсан олон асуудлуудыг шуурхай, зөв арга замаар шийдвэрлэж чадахгүй байна.

Цаашид ч улс орны өмнө тулгарч болох нийгэм, эдийн засаг, байгаль орчин, улс төрийн олон асуудлуудыг дан ганц төрийн оролцоо зохицуулалтаар бус иргэний нийгмийн бүхий л байгууллагуудын оролцоотойгоор, харилцан зөвшилцөж, ярилцаж, ил тод шийддэг байх, зах зээлийн эдийн засгийн тогтолцооны өөрийн жам гольдролоор аж ахуйн үйл ажиллагааг хөгжүүлэхийн тулд үйл ажиллагааны хөтөлбөрт эдийн засаг дахь төрийн оролцоог аль болох багасгах, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллага, иргэд, өрх гэр бүлийн хүлээх үүрэг хариуцлагыг илүү өндөржүүлэх бодлогыг түлхүү баримталж, холбогдох зорилтуудыг тусгалаа.

Монгол улс цаашид зах зээлийн эдийн засгийн чиг баримжаатайгаар хөгжих бодлогыг тууштай баримталж байгаа, өнгөрсөн хугацаанд хувийн хэвшил ихээхэн хөгжин бэхжиж, нийт эдийн засгийн 80 гаруй хувийг бүрдүүлэх болсон тул улс орны хөгжлийн дунд, урт хугацааны зорилтыг тодорхойлоход юуны өмнө хувийн хэвшлийнхэн, бизнес эрхлэгчдийнхээ санал бодол, бизнес стратегийн төлөвлөгөөнд үндэслэх учиртай гэж үзэж байна. Ийм ч учраас мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа юуны өмнө олон мянган үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг эгнээндээ нэгтгэсэн хувийн хэвшлийн олон нийтийн байгууллагууд болох Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эдийн нэгдсэн холбоо зэрэг төрийн бус байгууллагын саналыг авч хөтөлбөрт тусгасан болно.

УИХ-ын сонгуулийн явцад МАХН, Ардчилсан нам, Иргэний зориг намуудын зүгээс ард иргэддээ амалсан томоохон амлалтууд, улс орны хөгжлийн талаарх

үзэл бодол, хөгжлийн томоохон зорилтуудыг дэвшүүлэн тавьж улмаар УИХ-д суудал бүхий МАХН, Ардчилсан нам хамтран ажиллах гэрээг 2008 оны 9 дүгээр сарын 12-ний өдөр байгуулсан билээ.

Засгийн газрыг хамтран байгуулсан хоёр намын энэхүү гэрээнд хоёр намын сонгуулийн хөтөлбөрөөс утга санаа, зорилтын хувьд ижил төстэй, давхцаж байгаа зорилтуудыг нэгтгэн тусгаж, цаашид хоёр нам хэрэгжүүлэхээр харилцан зөвшилцөж, гэрээ байгуулсан тул энэхүү гэрээнд тусгагдсан 65 зорилтыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бүрэн тусгасан болно.

УИХ-ын 2008 оны намрын чуулганы нээлтийн хуралдаанд Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын хэлсэн үгэнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдах шаардлагатай зорилт, хөтөлбөрийг боловсруулах явцад анхаарах асуудал, хүрэх үр дүнгийн талаар нэн тодорхой тусгагдсан бөгөөд үйл ажиллагааны хөтөлбөрт Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан хөгжлийн нэг дэх үе шатны үндсэн гол зорилтууд бүрэн тусгалаа олох шаардлагатай гэж үзэж байгаагаа илэрхийлж, Засгийн газар тодорхой чиглэл, зөвлөмж өгсөн билээ.

Монгол улсын Ерөнхийлөгчийн өгсөн чиглэл, зөвлөмжийг анхааралтай судлан үзэж, Үндэсний хөгжлийн цогц бодлого ба Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд харилцан нягт уялдсан байх, хүрэх үр дүнтэй, тодорхой тооцоо судалгаатай байхад ихээхэн анхаарал хандуулан ажилласан болно.

Монгол улсын Засгийн газраас өмнөх жилүүдэд НҮБ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Европын холбоо зэрэг олон улсын байгууллага, БНХАУ, ОХУ, Япон улс, Герман болон бусад улс орон, Мянганы сорилын сан корпорацитай тодорхой салбар чиглэлүүдээр хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийг байгуулан ажиллаж, тусгагдсан зорилтыг хэрэгжүүлж ирсэн билээ.

Эдгээр гэрээ, хэлэлцээрт тусгагдсан зорилтуудыг цаашид цаг хугацаанд нь хэрэгжүүлэх, Засгийн газраас тавьж байгаа бодлогын зорилтуудтай уялдуулах, гадаад дотоод хөрөнгийн эх үүсвэрийг уялдуулахад анхаарал хандуулж, зарим тодорхой зорилтыг үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд тусгасан.

Монгол улсын Ерөнхий сайдын баталсан захирамж, өгсөн үүргийн дагуу үйл ажиллагааны хөтөлбөр нь нэгд, Засгийн газрын ирэх жилүүдэд баримтлах зорилтуудыг тусгасан хөтөлбөрийн төсөл, хоёрт уг хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний дэлгэрэнгүй төлөвлөгөө, гуравт, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн тооцоо гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэж байгаа болно.

Монгол улсын Засгийн газрын тухай хууль, УИХ-ын дэгийн тухай хуульд заасны дагуу **“Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”**-ийг УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх бөгөөд уг хөтөлбөрийг батлагдан гармагц Засгийн газраас уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг **“арга хэмжээ, хариуцах байгууллага, эзэн, хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн”** гэсэн дэлгэрэнгүй үзүүлэлтүүдээр батлан гаргаж, улмаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа нэн даруй зохион байгуулж, хэрэгжүүлж эхлүүлэхээр төлөвлөсөн.

Хөтөлбөрийн төсөлд олон тооны, томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зорилт болгон тусгасан бөгөөд эдгээр зорилт, төсөл, хөтөлбөр нь зөвхөн ирэх дөрвөн жилд багтаж хэрэгжих бус, түүний дараа дараагийн Засгийн газар ч үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр дүнд хүргэх, ашиглалтад оруулах төслүүд байгаа тул цаашид хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн бүхий л төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн тооцоог нарийвчлан гаргахад ихээхэн бэрхшээлтэй байлаа.

Иймд хөтөлбөрийн хөрөнгө санхүүгийн тооцоог:

- Нийгмийн чиглэлтэй амлалт зорилт, арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, төсөв,
- Эдийн засаг, дэд бүтцийн хүрээний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, төсөв,
- Монгол улсыг аж үйлдвэржүүлэх бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, эх үүсвэр,
- Тусгайлан хөрөнгө босгож, сан бүрдүүлэх шаардлагатай иргэдэд олгох 1,5 сая төгрөгийн талаарх хөрөнгө, эх үүсвэрийн тооцоо гэсэн үндсэн 4 бүлэг хөрөнгийн тооцоог Сангийн яам, холбогдох бусад яамдын мэргэжилтнүүдтэй хамтран тооцож гаргасан болно.

Одоогоор гаргаад байгаа урьдчилсан тооцооноос үзвэл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд жил тутам **5,3 - 8,9 триллион** төгрөгийн хөрөнгө, эх үүсвэр шаардагдахаар тооцогдсон бөгөөд энэ нь тухайн жилийн ДНБ-ний **75,0 -44,3 хувьтай тэнцэх**ээр байна.

Шинээр хэрэгжүүлэх төслийн бүтээн байгуулалт, барилга угсралтын ажил эхлэх 2009-2010 онуудад хөрөнгийн эрэлт хэрэгцээ харьцангуй их байх төлөвтэй байгаа бөгөөд энэ хугацаанд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад зах зээлээс хөрөнгө босгох нь чухал үүрэг гүйцэтгэх болно. Дараагийн жилүүдэд эдийн өсөлт эрчимжиж, төслүүдэд шаардагдах хөрөнгө, эх үүсвэрийн ачаалал, дарамт харьцангуй буурах бөгөөд 2011 оноос эхлэн дотоодын хувийн хэвшлийн зүгээс гаргах өөрийн хөрөнгө оруулалт багагүй хэмжээгээр нэмэгдэж, төслийн санхүүжилтэд гол үүрэг гүйцэтгэж эхэлнэ гэж төсөөлж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт хөрөнгийн чухам хэдэн хувийг хувийн хэвшил, хөрөнгө оруулагчид санхүүжүүлэх, хэдэн хувийг олон улсын байгууллагууд, гадаад орны зээл, тусламжаар санхүүжүүлэх, мөн хэдэн хувийг улсын төсөв, хөгжлийн сангаас санхүүжүүлэх боломжтой болохыг цаашид нарийвчлан тооцож гаргах шаардлагатай бөгөөд ийм тооцоог гаргахад багагүй хүн хүч, цаг хугацаа, нэмэлт тоо мэдээллүүд шаардагдаж байгаа тул хөтөлбөрийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж эхлэхээс өмнө хөрөнгийн тооцоог улам нарийвчлан гаргах шаардлагатай болно.

Хөрөнгийн тооцоог цаашид нарийвчлан гаргахад холбогдох яамд, агентлагуудын идэвхитэй оролцоо, санаачлага, хамтын ажиллагаа шаардагдаж байгааг анхаарна уу. Хөрөнгө санхүү, эх үүсвэрийн урьдчилсан тооцоог хөтөлбөрт хавсаргав.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх явцад ч, хөтөлбөрийг батлан гаргасны дараа хэрэгжүүлэх явцдаа ч хөрөнгө санхүү, эх үүсвэр, түүнийг хаанаас ямар арга замаар бүрдүүлэх, босгох талаар тооцоог улам бүр нарийвчлан тооцож, нягтлах, одоогоор боловсруулж эхлээгүй байгаа томоохон төсөл, хөтөлбөрүүдийн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ-ийг богино хугацаанд боловсруулан гаргах шаардлагатай болохыг хөтөлбөрийн төслийг боловсруулсан ажлын хэсгийн гишүүд, мэргэжилтнүүдийн зүгээс Засгийн газрын гишүүдэд уламжилж, санал болгож байна.

Аливаа төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх үндэс нь зөвхөн зорилт, арга хэмжээг төлөвлөж, батлаад орхих бус харин тэдгээрийг бодитой төлөвлөгөө болгон боловсруулах, техник, эдийн засгийн үндэслэлийг мэргэжлийн түвшинд нарийвчлан боловсруулах, төслийг маш сайн удирдлага, менежментээр хангаж ажиллах, төслийг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй эх үүсвэр, хөрөнгийг бүрдүүлэх зэрэг олон талын хүчин зүйлээс хамаарч амжилтад хүрэх эсэх нь шалтгаалах тул дээрх үе шат болгоныг зөв зүйтэй төлөвлөж, шуурхай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хөтөлбөрийг төлөвлөсөн цаг хугацаанд нь багтаан, үр дүнтэй амжилттай хэрэгжүүлэхийн тулд зөвхөн УИХ, Засгийн газар, яамдууд дангаараа ажиллах бус хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ тус бүрийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, олон нийтийн байгууллагууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, түншлэгчид, гадаадын хөрөнгө оруулагчид, ард иргэдтэйгээ сайтар зөвлөлдөж, тэдний санаачлага, идэвхитэй оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжтой гэдгийг бид онцгой анхаарч ажиллах шаардлагатай юм.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад цөөнгүй тооны хөтөлбөрийг шинээр боловсруулан гаргаж, хэрэгжүүлэх шаардлага тулгарч байгаа бөгөөд эдгээр хөтөлбөрийг ойрын жилүүдэд (эхний 1-2 жилд багтаан батлан гаргасан байхыг зорих) шинээр боловсруулах шаардлагатай гэж үзсэн хөтөлбөрүүдийн жагсаалтыг тусгайлан гаргаж хавсаргасан болно.

Ажлын хэсэг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Их Хурлын ээлжит тав дахь удаагийн сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар нь Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, 2008 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон МАХН болон Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, тэдгээр намуудын УИХ-ын сонгуулийн дараа байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд үндэслэн 2008-2012 онуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны энэ үеийн гол зорилго нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын эхний үе шатны зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, эрдэс түүхий эдийн нөөцөд тулгуурлан улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, иргэдийнхээ аж амьдралыг сайжруулан, төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, өндөр хариуцлагатай ёс зүйт байдлыг хангаж, бүх шатны төр, засгийн байгууллагын нэр хүндийг дээшлүүлэх явдал мөн.

Энэхүү зорилгын хүрээнд Монгол Улсын Засгийн газар дараахь тэргүүлэх чиглэл, зорилтыг хэрэгжүүлнэ:

1. **Ашигт малтмалын салбарын хөгжлийг түргэтгэж** хууль эрх зүйн орчныг шуурхай шинэчлэн гаргах, ашигт малтмалын томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг бодитойгоор хэрэгжүүлж тус салбарын орлогоос иргэдэд хуваарилах.
2. **Эдийн засгийн төрөлжилтийг гүнзгийрүүлэх** бодлогыг тууштай баримталж боловсруулах аж үйлдвэр, аялал жуулчлал, тээврийн үйлчилгээний салбарын ДНБ-ний бүтцэд эзлэх хувийн жинг нэмэгдүүлж хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийг олон улсын стандартад нийцсэн хэмжээнд боловсруулж, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнээр дотоодын хүнсний хэрэгцээг бүрэн хангах.
3. Монгол Улсыг аж үйлдвэржүүлэх хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхдээ эдийн засгийн утгаар, зах зээлийн жамаар үүсэж байгаа **Бүс нутгаар нь цогцоор хөгжүүлэх**, бүс нутгийн хөгжилд “Хувийн хэвшил-Засгийн газрын хамтарсан” хөрөнгө оруулалтын зарчим баримтлах.
4. **Транзит Монгол хөтөлбөрийг** хэрэгжүүлэхэд томоохон ахиц дэвшил гаргах, Монгол Улсын бизнесийн орчин нөхцөлд гадаад худалдааны орчин

нөхцөлийн улмаас учруулж байгаа саад бэрхшээлийг багасган, дэд бүтцийн орчин нөхцөл, ложистик сүлжээг эрс сайжруулах.

5. **Бүх шатны боловсролыг** эрхэмлэн хөгжүүлэхийн хамт хөдөлмөрийн зах зээлийг бие даан ажиллах механизмтай болгон хөгжүүлэх, ажил олгогчид, үйлдвэрлэл эрхлэгчдийн захиалга, эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, инженер техникийн боловсролыг түлхүү эзэмшүүлэх замаар мэдлэгт тулгуурласан эдийн засгийн тогтолцооны суурийг бүрдүүлэх.
6. **Ажлын байр**, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, иргэдийн идэвхи санаачилгыг дэмжих, бизнес эрхлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүн бүрийг эдийн засгийн идэвхитэй, хөдөлмөрийн чадвартай байлгахад чиглэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, ядуурлыг бууруулах.
7. **Экосистемийн тэнцвэрт байдлын** алдагдлыг зогсоох, хамгаалах, ашиглах замаар хөгжлийн тогтвортой орчинг бий болгох.
8. Авлига, хүнд суртлаас ангид, хариуцлагатай **улс төрийн ардчилсан тогтолцоог** хөгжүүлэх.

Хөтөлбөрийг боловсруулахад үндэслэл болгосон үндсэн баримт бичгүүд:

- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого;
- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд;
- МАХН, Ардчилсан намын хамтран ажиллах гэрээ;
- Монголы үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос ирүүлсэн санал, тэдгээртэй байгуулсан санамж бичиг;
- Монгол Улсын Засгийн газраас Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, НҮБ зэрэг олон улсын байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, хөтөлбөрүүд;
- УИХ, Засгийн газраас батлан гаргасан Үндэсний хөтөлбөрүүд;

Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах урьдчилсан нөхцөлүүд:

- Улс төрийн тогтвортой байдал, УИХ, Засгийн газрын тогтвортой үйл ажиллагаа;
- Төрийн байгууллагуудын хүсэл зориг, шуурхай үйл ажиллагаа, зөв зохион байгуулалт;
- Үндсэн чиглэл, төсөв, мөнгөний бодлого болон бусад үндэсний хөтөлбөрийг харилцан нягт уялдаатай байдлаар батлах, хэрэгжүүлэх;
- Нийгмийн шинж чанартай томоохон шинэ амлалт, популизм хийхгүй байх;
- Хувийн хэвшил - төрийн байгууллагын харилцан ойлголцол, нийгмийн түншлэл, хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх, ажиллуулах;
- Төв, орон нутгийн удирдлагын нягт хамтын ажиллагаа, уялдаа;
- Боловсон хүчний байгаа хүч нөөцийг зөв хуваарилах, зохистой байршуулах.

Дунд хугацаанд учирч болох гадаад, дотоод бодит эрсдэлүүд:

- Улс төрийн тогтворгүй байдал үүсэх, Засгийн газрыг огцруулах шаардлага тавигдах;
- Засаглалын түвшин дэх зогсонги байдал, УИХ болон төрийн бусад байгууллагын үйл ажиллагаанд ямарваа саатал үүсэх, асуудлыг шуурхай шийдвэрлэх боломж бүрдэхгүй байх;
- УИХ-ын сонгуулийн явцад улс төрийн намуудын амалсан нийгмийн шинж чанартай томоохон амлалтыг хэрэгжүүлэх талаар иргэдийн хүлээлт, шаардлага;
- Байгаль цаг уурын өөрчлөлтөөс хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт гарч болох эрсдэл;
- Дэлхийн зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнэ ханшийн огцом хэлбэлзэл ба уналт;
- Эрчим хүчний эх үүсвэр, үүний дотор газрын тосны үнэ ханш, нэмэгдэл экспортын татварын дарамт, ачаалал ирэх.

Хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгслэлүүд:

Улс орны эдийн засагт зайлшгүй байвал зохих шаардлагатай зах зээлийг зүй зохистой бүрдүүлэх, зөв гольдролоор нь хөгжүүлэх, байнгын ажиллагааны механизмыг бий болгож, хөгжүүлнэ. Үүнд:

- *Санхүүгийн зах зээл: Мөнгөний ба хөрөнгийн зах зээл*
- *Хөдөлмөрийн зах зээл*
- *Түүхий эдийн зах зээл*
- *Технологи, мэдээллийн зах зээл*
- *Мэдлэг ухаан, инновацийн зах зээл*

Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга замууд:

- Боловсрол, үүний дотор мэргэжлийн боловсролыг түлхүү дэмжих замаар ажиллах хүчний нөөцийг хангалттай, хүрэлцэхүйц түвшинд бэлтгэх, зөв зохистой байршуулах;
- Улс орны хөрөнгө, санхүүгийн нөөцийг зүй зохистой ашиглах, хувийн хэвшил ба төрийн хамтарсан санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, ашиглах;
- Ашигт малтмал, байгалийн нөөц баялгийг хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зохистой ашиглахын зэрэгцээ, хүний амьдрах орчинд таагүй нөлөө үзүүлэхгүй байх арга замыг сонгох;
- Аливаа зорилтыг хэрэгжүүлэх хамгийн зүй зохистой, дэвшилтэт, үр өгөөжтэй арга зам, технологийг сонгож хэрэглэх, эдийн засаг, бизнес, нийгмийн бүхий л салбарт байнга шинэ технологи, инновацийг нэвтрүүлж байх;

- Улс орны хүн хүч, оюуны чадамж, хөрөнгө санхүү, байгалийн нөөц баялгийг хамгийн үр өгөөжтэй, зөв зүйтэй ашиглаж, удирдах төрийн чадвар, чадамжийг засаг захиргааны байгууллагын бүхий л түвшинд бүрдүүлэх.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө, гадаад түншүүдийн зээл, тусламж, гадаадын хөрөнгө оруулалт, улс, орон нутгийн төсөв, хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрийг ашиглана. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийн хувьд улсын төсөв, хөгжлийн сангийн оролцоо нийт хөрөнгийн 30-35 хувиас хэтрүүлэхгүй байх бодлогыг баримтална.

Талууд эдгээр хөрөнгө, эх үүсвэрийн тооцоог жил бүр тодотгож тооцож байна.

Бодит салбарын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг санхүүгийн зах зээлийн олон төрлийн арга хэрэгслийг ашиглан бүрдүүлж, хөрөнгө оруулалтын төрөлжсөн болон тусгай сангууд, бусад арга замаар хуримтлуулан, зарцуулна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх зарчим нь:

- Засгийн газрын манлайлалд түшиглэх,
- Иргэний нийгэм, үүний дотор хувийн хэвшлийн “нийгмийн хариуцлага”-ын чиглэлээрх санаачлагыг хөхиүлэн дамжих замаар Засгийн газар -Иргэний нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх,
- Бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ гадаад түншүүдийн хамтын ажиллагаа, дэмжлэгт тулгуурлах,
- Хөрөнгө мөнгө, нөөцийг байршуулах, түүний зарцуулалтад хариуцлагатай, ил тод, тунгалаг байх зарчмыг дээдлэх,
- Төрийн зохицуулалт үндэсний эрх ашгийг дээдэлсэн, хөрөнгө нөөцийг тэргүүлэх чиглэлд төвлөрүүлэн, асуудлыг эрэмбэлэн үе шаттайгаар шийдвэрлэх,

Нэг. Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах бодлого

Нийгэм, эдийн засаг, үйлдвэржилт, байгаль орчин, бүс нутаг, дэд бүтэц, засаглалын оновчтой бодлого хэрэгжүүлсний үндсэн дээр хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн таатай орчин бүрдүүлж, иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулна.

1. Шинээр гэр бүл бологсад, нийт болон шинэ төрсөн хүүхдэд мөнгөн тусламж, тэтгэмжийг үргэлжлүүлэн олгоно.
2. Шинээр 3 дахь хүүхдээ төрүүлсэн гэр бүлд 300.0 мянган төгрөг нэг удаа, Алдарт эх 2 дугаар одонтой эхэд 50.0 мянга, 1 дүгээр одонтой эхэд 1.0 сая төгрөгийн тэтгэмж олгоно.
3. Үнийн өсөлтөөс бага орлоготой, эмзэг бүлгийн иргэдээ хамгаалах бодлого явуулж, тэдэнд хүнсний болон зайлшгүй шаардлагатай бусад дэмжлэг үзүүлнэ.
4. Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, төрөл, хэлбэрийг оновчтой болгоно.
5. Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлж хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг уртасгана.
6. Гадаад оронд удаан хугацаагаар ажиллаж, сурч, хөдөлмөрлөж, амьдран сууж байгаа Монгол Улсын иргэдийн эрх зүй, нийгмийн асуудлаар тусгайлсан хөтөлбөр, хууль боловсруулан гаргаж, хэрэгжүүлнэ.
7. Стратегийн болон бусад томоохон орд газруудаас жил бүр олох орлогоос сан бүрдүүлж, Монгол Улсын иргэн бүрт 1,5 сая төгрөгийг хүртээнэ.
8. Өрхийн сарын дундаж орлогыг 1.0 саяас доошгүй төгрөгт хүргэхийн хамт дундаж орлоготой иргэдийн хувь хэмжээг нийт хүн амын 30 хувьд хүргэнэ.
9. Цалин тэтгэвэр, тэтгэмжийг 2008 оны эцсийн түвшнээс 3 дахин өсгөнө.
10. Эдийн засгийн өсөлтийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх, орлогын өсөлтийг хангах замаар ядуурлыг 2 дахин бууруулна.
11. Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлж, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх замаар нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээг 5.000 ам.долларт хүргэнэ.
12. Хүн амыг эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр жигд, хүртээмжтэй ханган хүн амын эрүүл мэндийг хамгаалж, өвчлөлөөс урьдчилан сэргийлнэ.
13. Монгол Улсын нутаг дэвсгэрт явагдаж байгаа бүхий л үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаанд тавигдах эрүүл ахуйн шаардлагыг өндөржүүлнэ.
14. Айл өрх бүр цахилгаан эрчим хүчээр хангагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

15. Хот суурин газрын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулахын зэрэгцээ оршин суугчдын оролцоотойгоор орон сууцны хороолол болгон хөгжүүлэх бодлогыг дэмжиж хэрэгжүүлнэ.
16. Улаанбаатар хот, томоохон хот суурин газрууд дахь агаар, ус, хөрсний бохирдлыг багасгаж, иргэдийн ажиллаж, амьдрах эрүүл орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
17. Хот, төвлөрсөн болон суурин газруудад хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлж, хог боловсруулах үйлдвэр байгуулна.
18. Хүн амын эрүүл ахуйн шаардлагад нийцсэн цэвэр, ундны усны хангамж, хүртээмжийг эрс нэмэгдүүлнэ.

Хоёр. Эдийн засаг, үйлдвэржүүлэлтийн бодлого

2.1. Макро эдийн засаг, санхүүгийн бодлого

1. Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг жилд 12 хувиас доошгүй түвшинд хүргэн, эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн нөхцөлийг бүрдүүлнэ.
2. Эдийн засгийн өсөлтийг хангах, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг бататгах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бодит салбарын хөгжлийг тэтгэхэд чиглэсэн төсөв, мөнгөний бодлого явуулна.
3. Ирэх жилүүдэд төсвийн хүрээний мэдэгдэл, үндсэн чиглэл, улсын төсөв, төсвийн тодотголыг боловсруулах, батлах явцдаа улсын төсвийн нийт зарлагыг ДНБ-ний 33 хувиас хэтрүүлэхгүй байх, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын шинжтэй зарлагаас бусад урсгал зардыг хурдацтай нэмэгдүүлэхгүй байх, гадаад өрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах бодлогыг чанд баримтлана.
4. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, олон улсын түүхий эд, санхүүгийн зах зээлд цаашид гарч болох аливаа хэлбэлзэл, хямралын эрсдэлээс үндэсний эдийн засаг, санхүүгийн тогтолцоог хамгаалах зорилгоор “Төсөв, санхүүгийн хариуцлагын тухай” хууль боловсруулан гаргаж, мөрдүүлнэ.
5. Төсвийн зарлагыг зохистой түвшинд хязгаарлан, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлж, төсвийг алдагдалгүй байлгах бодлого баримтална.

6. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог зөв төлөвшүүлэх зорилгоор санхүүгийн, түүхий эдийн болон хөдөлмөрийн зах зээлийг зүй зохистой бүрдүүлж, үйл ажиллагааг нь зүгшрүүлнэ. Аж ахуй, бизнесийн үйл ажиллагаанд төр хэзээ, ямар хэлбэрээр оролцохыг хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулна.
7. Эдийн засгийн бүтцийг сайжруулж, ДНБ-д аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх бодлого баримтална.
8. Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэх татварын бодлого явуулна.
9. Инфляцийг бууруулах төсөв, мөнгө, валютын ханшны болон гадаад худалдааны харилцан уялдаа бүхий бодлого хэрэгжүүлнэ. Үнэ, тарифын судалгаа хийнэ.
10. Экспортын үйлдвэрлэлийг дэмжиж, төгрөгийн ханшийг харьцангуй тогтвортой байлгах бодлого хэрэгжүүлнэ.
11. Үйлдвэрлэл, хэрэглээний зохистой харьцаа бүхий бүтцийг бий болгох, тэргүүний техник, технологийг импортлох, нутагшуулах, боловсруулах үйлдвэрийн өсөлт, экспортыг нэмэгдүүлэхэд гаалийн тарифын бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
12. Эдийн засаг, улсын төсөвт дарамт учруулахгүй байхуйц гадаад зээлийн бодлогыг баримтална. Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл, өрийн үйлчилгээний үзүүлэлтүүдийг УИХ-аас тогтоосон зохистой түвшнээс хэтрүүлэхгүй байлгана.
13. Эдийн засгийн үр ашигтай томоохон төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг түлхүү ашиглах бодлого явуулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого баримталж, хөрөнгө оруулалтын тогтвортой орчинг хангана.
14. Гадаадын хөрөнгө оруулалтын орчин, түүнийг татах боломжийг бүрдүүлэх, сурталчилах, гадаадын хөрөнгө оруулалтыг бүртгэх, түүний гарал үүсэл, төрөл бүтэц, үр өгөөжид дүн шинжилгээ хийх төрийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулагчдад үйлчлэх “Нэг цонхны үйлчилгээ”-г өргөн нэвтрүүлнэ.
15. Банк, санхүүгийн тогтолцоо, үйлчилгээг боловсронгуй болгож, зээлийн хүүг бууруулан, хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчин бүрдүүлнэ.
16. Засгийн газрын шугамаар гадаад орон, олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээлийн үр ашгийг дээшлүүлэх, цаашид гадаад зээлийг багасгах, аль болох буцалтгүй тусламж авах бодлого баримтална.

17. Санхүүгийн салбарын хөгжлийг хангах, санхүүгийн аливаа хямралын эрсдэлээс урьдчилан сэргийлж, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн санхүүгийн салбарын дунд хугацааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгоно.
18. Даатгалын зах зээлийн хөгжлийг дэмжиж, түүний нийгмийн амьдралд үзүүлэх үр нөлөөг өргөжүүлнэ. Хувь хүний амьдралын даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
19. Нийгмийн даатгалын сангийн бие даасан үйл ажиллагааг дэмжих, шинэ менежмент нэвтрүүлэх замаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг урт хугацааны хөрөнгө оруулалтад ашиглах эрх зүйн орчныг бий болгож, хэрэгжүүлнэ.
20. Санхүүгийн зуучлалын хүрээг өргөтгөн, нягтлан бодох бүртгэл, аудит, хөрөнгийн бүртгэл-мэдээлэл, хөрөнгий үнэлгээний үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх чиглэлээр эрх зүйн орчинг сайжруулна.
21. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг олон улсын санхүүгийн зах зээлийн нийтлэг шаардлагад нийцүүлэн боловронгуй болгож, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлнэ. Эдийн засгийн томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад шинээр хувьцаа гаргах, төрийн оролцоотой хувьцаат компани, корпораци байгуулах, өрсөлдөх чадвар бүхий үнэт цаас, бондыг гадаад санхүүгийн зах зээлд гаргах зэрэг зах зээлийн дэвшилтэт хэлбэрүүдийг ашиглан хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
22. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үүднээс зээлийн баталгаа, зээлийн даатгал, барьцааны тогтолцоог төлөвшүүлэх эрх зүйн орчинг бий болгоно.
23. Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, өрсөлдөөний тухай ойлголт, соёлыг нийгмийн сэтгэлзүйд төлөвшүүлэх, зах зээлийн өрсөлдөөний нэн шаардлагатай орчинг бүрдүүлнэ.
24. Үндэсний бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанарын өрсөлдөх чадвар, хэрэглээний аюулгүй байдлыг дээшлүүлэх, экологийн аюулгүй орчинг бүрдүүлэх, хэрэглэгчдийг чанартай аюулгүй бүтээгдэхүүнээр хангахад стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээгээр дэмжлэг үзүүлэх, ажлыг эрс сайжруулж, бүсчлэн хөгжүүлэх хөтөлбөр гаргаж хэрэгжүүлнэ.
25. Экологийн аюулгүй байдалд тавих төрийн хяналтыг эрс чангатгаж, хүнс, эм, барааны аюулгүй байдлыг хангахад стандартын оновчтой бодлого хэрэгжүүлнэ.
26. Оюуны өмчийг асуудлаарх төрөөс баримтлах бодлогыг мэргэжлийн өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэх, нийгмийн хөгжил, олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсруулж батлан, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

27. Оюуны өмчийн мэдлэгийг бүх нийтэд түгээх зорилгоор оюуны өмчийн бүх нийтийн боловсрол олгох, мэдээлэл түгээх эхний шатны арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2. Үйлдвэржүүлэх бодлого

1. Монгол Улсыг үйлдвэржүүлэх цогцолбор төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
2. Уул уурхайн салбарын бодлогыг шинэчлэн тодорхойлж, ашигт малтмалын хуулийг шинэчлэн өөрчилнө.
3. Стратегийн томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулна.
4. Геологи, уул уурхай, газрын тос, цөмийн эрчим хүчний эрх зүйн орчныг боловсронгуй болгон, улсын зардлаар геологийн хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн орд газруудад төрийн мэдлийн хувийг 51-ээс дээш байлгах бодлого барина.
5. Геологийн тогтоц, ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтлыг судлах, ерөнхий үнэлгээ өгөх, геологийн зураглал хийх болон бусад судалгааны ажлыг эрчимжүүлнэ.
6. Ураны баталгаажсан баталгаажсан нөөцийг нэмэгдүүлж, ураны олборлолтод хөрөнгө оруулах сонирхол бүхий стратегийн хөрөнгө оруулагч нарыг сонгоно.
7. Катодын зэс үйлдвэрлэх гидрометаллург, алт хайлуулах, кокс-хими, хар металлургийн аж үйлдвэрийн цогцолбор барьж байгуулах төсөл боловсруулж , хэрэгжүүлж эхэлнэ.
8. Боловсруулах үйлдвэрийн Монгол брэндийг буй болгож, ноолуур, арьс ширийг 100 хувь хагас болон эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулах зорилт тавьж , гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
9. Барилга, барилгын үндсэн материал болох цемент, арматурын үйлдвэрлэлийг хотын болон бүсийн хэмжээнд хөгжүүлнэ.
10. Дотоодын түүхий эдэд түшиглэн ханын материал, арматур төмөр хийц, цемент зэрэг барилгын материалын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээс бүрэн хангана.
11. Бизнес эрхлэх орчныг бүх талаар сайжруулж, өндөр технологи бүхий жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

12. Аймаг, сумдын онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн жижиг үйлвэр, үйлдвэрлэл технологийн паркийг байгуулж, орон нутгийн загвар үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
13. Нефть боловсруулах, нүүрсийг шингэрүүлэх, хийжүүлэх төслүүдийг хэрэгжүүлж бензин, шатахуунаар дотоодын хэрэгцээгээ хангаж эхэлнэ.
14. Ураны эрэл судалгаа, хайгуул, олборлолт, боловсруулалт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
15. Цөмийн эрчим хүчийг ашиглах нарийвчилсан судалгаа, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан гаргана. Цацрагийн хяналт, аюулгүй байдлыг сайжруулна.
16. Эрдэс баялгийн салбарын бодлогыг шинэчлэн тодорхойлж, “Ашигт малтмалын тухай” хуулинд нэмэлт өөрчлөлт оруулна. Бичил уурхайг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
17. Геологи, эрдэс баялгийн судалгааны стандарт, норм, норматив зэргийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутагт судалгааны ажил явуулах харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
18. Нутаг дэвсгэрийн геологи, ашигт малтмалын судалгаа хийж, ерөнхий үнэлгээ өгөх, геологийн зураглал, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи болон бусад сэдэвчилсэн судалгааны ажлыг эрчимжүүлнэ.
19. Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл хайгуулын шатны ажилд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр судалгааны хүрээг өргөжүүлж, улсын эрдэс баялгийн сан хөмрөгийг баяжуулна.
20. Улсын болон хувийн хөрөнгөөр хийгдсэн эрдэс баялгийн бүх төрлийн геологийн судалгааны ажлын үр дүнг нэгтгэн боловсруулж, үндэсний геомэдээллийн санг бүрдүүлнэ.
21. Кадастрын бүртгэлийн системийг бүрэн автоматжуулж харилцагчдад үзүүлэх үйлчилгээг чанартай, шуурхай болгоно.
22. **Тавантолгой, Оюутолгой, Төмөртэй, Асгат** болон бусад стратегийн ач холбогдол бүхий ордуудыг ашиглаж эхэлнэ. Монгол Улсын иргэн бүрт ашгаас нь тогтмол хувь хүртэж байх орлогын эх үүсвэрийг бүрдүүлнэ.
23. Уул уурхайн үйлдвэрлэлд байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, шилдэг техник, технологийг нэвтрүүлж, эвдрэлд орсон талбайг нөхөн сэргээх, нөхөн сэргээлтийн зардлыг улсын төсвийн дансанд бүрэн байршуулдаг болгоно.
24. Уран, цөмийн эрчим хүчний эрх зүйн орчинг бүрдүүлж, **Дорнод, Гурванбулаг** зэрэг ураны ордуудыг стратегийн хөрөнгө оруулагчтай хамтран ашиглаж эхэлнэ.

25. Хүнд үйлдвэрийг хөгжүүлж, металлурги, катодын зэсийн үйлдвэрлэл, кокс-хими, барилгын материалын аж үйлдвэрийн цогцолбор барьж байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
26. **Багануур, Шивээ-Овоогийн** уурхайнуудын техник, технологи, эдийн засгийн чадавхийг сайжруулах хөрөнгө оруулалтыг зах зээлийн зарчмын дагуу шийдвэрлэж, нүүрс олборлолт, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг авна.
27. Дулааны шинэ цахилгаан станцын түлшний хангамжтай холбогдуулан **Шивээ-Овоогийн** уурхайг өргөтгөх ажлыг эхлүүлнэ. Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцуудын нүүрсний хангамжийг шийдвэрлэнэ.
28. Нүүрсийг гүн боловсруулах эрх зүйн орчинг бүрдүүлж, нүүрс шингэрүүлэх үйлдвэрлэлийг бий болгоход хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
29. Гэр хорооллын хэрэглэгчдийг экологийн цэвэр түлшээр хангах ажлыг эхлүүлж, орлого багатай иргэдэд тус түлшийг худалдан авахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.
30. Газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлж газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулан олборлолтыг нэмэгдүүлнэ. Гуравдагч орнуудаас газрын тос худалдан авах, хөрш орнуудад боловсруулах боломжийг бүрдүүлнэ. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.
31. Нүүрсний давхаргын метан хий, байгалийн хийн хайгуулын ажлыг эхлүүлж тойм нөөцийг тогтооно. Хийн түлшний салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлнэ. “Хийн хангамжийн тухай” хуулийг хэлэлцүүлнэ.
32. Эрчим хүчний салбарын эрх зүй, зах зээлийн загварыг боловсронгуй болгоно.
33. Төвийн болон Баруун бүсийн эрчим хүчний системд цахилгаан, дулааны шинэ эх үүсвэр барих, одоо ажиллаж байгаа эх үүсвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. **Баруун бүс болон Улаанбаатар хотын** цахилгаан, дулааны дамжуулах, түгээх сүлжээг шинэчлэж, өргөтгөнө.
34. **Багануур-Өндөрхаан-Чойбалсан, УБ-Мандалговь-Таван Толгой-Оюу толгойн** 220 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж, **Багануур-Чойр, Чойр-Мандалговийн** 220 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг 2 хэлхээтэй болгоно. Цагаан Суваргын уурхайн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.
35. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрийг ашиглан систем, баг, малчин айл өрхийн цахилгаан хангамжийг сайжруулна. Аймаг орон нутгийн дулаан хангамжийн системийг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

2.3. Хөдөө аж ахуйн салбарын хөгжил, хүнсний аюулгүй байдлын бодлого

1. Дотоодын мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнээр (мах, сүү, гурил, төмс, хүнсний ногоо) хүн амын хүнсний хэрэгцээг бүрэн хангах бодлого, зохион байгуулалтын арга хэмжээ авна.
2. Хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгааг тогтоох өндөр хүчин чадал бүхий лабораторийг нийслэл, аймгийн төв, хилийн боомтуудад бий болгож, бэхжүүлнэ.
3. Хүнс, хөдөө аж салбарт орчин үеийн шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэн, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. Экологийн цэвэр бүтээгдэхүүнийг экспортод гаргах эрх зүйн орчныг бүрдүүлж, гэрээ хэлэлцээрийг байгуулна.
4. Хүнсний хангамж, чанар, аюулгүй байдлыг хангах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчинг бүрдүүлж, “Хүнсний хангамж, шимт чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлнэ.
5. Хүн амыг чанартай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах, хэрэглээнд үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан хүнсний хувийн жинг тогтвортой нэмэгдүүлнэ. Хүнсний бүтээгдэхүүн, ундны усны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах хяналт, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгоно.
6. Малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх үржлийн ажил үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжируулан, сүргийн бүтцийг оновчтой хэмжээнд байлгах бодлого хэрэгжүүлэн, бүсийн төв, томоохон хот суурингийн ойролцоо эрчимжсэн мал ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
7. Хөдөөгийн иргэд бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд арилжаалах, шууд худалдаалах биржийн сүлжээ байгуулна.
8. Малчдыг мал бүхий иргэний орлогын албан татвараас чөлөөлж, хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.
9. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
10. Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлж, биотехнологи нэвтрүүлэх, Атрын 3 дахь аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
11. Мал сүргийг эрүүлжүүлэх ажлыг шат дараатай хийж, мал эмнэлгийн оношлогоо, эмчилгээг сайжруулах, дотоодын үйлдвэрлэлээр малын эмийг хангах арга хэмжээ авна.

12. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын талаар төрөөс баримтлах бодлого боловсруулж, газрын төлөв байдлын болон нөөцийн үнэлгээхийг мэдээллийн нэгдсэн сантай болох, бэлчээрийг хамгаалах, сайжруулах, усжуулах, хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлнэ.
13. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөрөө хорших, хөрөнгө хүчээ нэгтгэх, хоршоо, нөхөрлөл бүлэг болон зохион байгуулагдаж ажиллахыг зээл татварын бодлогоор дэмжинэ.

2.4. Хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн бодлого

1. Төр болон хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг /PPP/ сайжруулах, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог боловсронгуй болгох хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барих, тодорхой хугацаанд ашиглуулах, ажиллуулсны дараа төрд шилжүүлэн өгөх эрх зүйн орчинг зохицуулах хуулийн төслийг боловсруулж батлуулна.
2. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулж батлуулна.
3. “Хотууд” үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
4. Газар ашиглалтыг сайжруулж, газрын шинэтгэлийг эрчимжүүлэн Монгол Улсын иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.
5. GPS-ийн технологийг нэвтрүүлэх, Монгол улсын GPS-ийн сүлжээ байгуулах 2 дахь шатны ажлыг хийж, өндрийн сүлжээг сайжруулна.
6. Газрыг зохистой ашиглах, хамгаалах нэгдсэн бодлого хэрэгжүүлж, газрын болон эд хөрөнгийн бүртгэлийн өнөөгийн тогтолцоог сайжруулан, газар төлөвлөлт, газрын үнэлгээний аргачлалыг шинэчилнэ.
7. Бага, дунд орлоготой иргэдийг орон сууцжуулах бодлогыг түлхүү баримталж, “Нийслэл болон орон нутагт 100 мянган айлын орон сууц барих” төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.
8. Нийтийн аж ахуй, үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
9. Нийслэл хотыг олон улсын жишигт хүргэх, эрүүл, аюулгүй, тохилог орчин, найдвартай дэд бүтэц бүхий томоохон хот болгон хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
10. Гэр хорооллыг сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөрийг аймаг, нийслэл, бүсийн тулгуур төвүүдэд хэрэгжүүлнэ.

11. Их, дээд сургуулиудын хотхоныг хөгжүүлэх төлөвлөлтийг боловсруулж хэрэгжүүлж эхэлнэ.
12. Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудлыг түшиглэн баригдах хотын ерөнхий төлөвлөгөө боловсруулах.
13. Стратегийн томоохон орд газруудыг түшиглэсэн орчин үеийн шийдэл бүхий хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.
14. Нийслэл болон бүс нутгуудыг бие даан хөгжих эдийн засаг, санхүүгийн чадавхитай болгох, суурь дэд бүтцийг бүрдүүлнэ.
15. Олон улсын нисэх онгоцны буудал, нисэх буудлын хотхон, говийн бүсийн төмөр зам, ус цахилгааны дэд бүтцийн сүлжээ, зүүн бүсийн төмөр зам зэрэг томоохон /мега/ төслийн зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ.
16. Улаанбаатар болон томоохон суурин газрын нийтийн зорчигч тээвэрт хөдөлгөөний аюулгүй байдал, стандартын шаардлага хангасан 500 их багтаамжийн автобусаар хөдлөх бүрэлдэхүүнийг шинэчилж, нийтийн тээврийн үйлчилгээнд хийн түлшээр ажилладаг 2000-аас доошгүй таксигаар хангахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.
17. Монгол Улсын төмөр замын тээврийн дамжин өнгөрүүлэх чадавхийг сайжруулж, үйлчилгээний чанар, хамрах хүрээг өргөтгөн, техник, технологийг шинэчлэх хүрээнд **ачааны вагоны тоог 2000 вагоноор** нэмэгдүүлнэ.
18. Агаарын тээврийн салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, олон улсын нислэгийг өргөжүүлнэ. Олон улсын агаарын карго тээвэрлэлтийн үйлчилгээг бий болгоно.
19. “Мянганы зам” төслийн ажлыг эрчимтэй үргэлжлүүлэн, аймгийн төвүүдийг нийслэл Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлнэ.
20. Олон улсын авто замын сүлжээнд холбогдох **Замын-Үүд-Улаанбаатар-Алтанбулаг** чиглэлийн хурдны зам болон **Ярант-Хөвд-Өлгий-Улаанбайшинт** чиглэлийн хатуу хучилттай авто замыг барина.
21. Говийн бүсийн **авто замын сүлжээг** барьж эхэлнэ.
22. Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн авто замын сүлжээг шинэчлэн өргөтгөж, хоёр түвшний уулзвар, гүүрэн болон нүхэн гарц, авто зогсоол барина.
23. Бүх төрлийн зам, замын суурь тавих, сэргээн засварлахад дэлхийн жишигт нийцсэн, экотехнологийг нутагшуулах чиглэлээр аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

24. Нийслэлд дулааны болон эрчим хүчний шинэ эх үүсвэр байгуулна.
25. Улаанбаатар хот болон бүс нутгуудад зорчигч тээврийн болон ачааны төрөлжсөн терминал аж ахуй, логистик төвийг байгуулж, хүн амын хүнсний хангамжийн аюулгүй байдлыг хангасан тээврийн хэрэгслийн паркийг бий болгоно.
26. Орон зайн мэдээллийн сан дээр тулгуурласан зөөлөн дэд бүтцийг \хаягжуулалт, кодчилал, бар код, зип код гэх мэт\ бий болгож төрийн үйлчилгээг шинэ шатанд гарган, үр ашгийг дээшлүүлнэ.
27. Мэдээлэл холбооны хүртээмжийг нэмэгдүүлэх эрх зүй, бодлого, зохицуулалтын орчинг боловсронгуй болгоно.
28. Мэдээлэл холбооны дэд бүтцийг өргөтгөн шинэчилж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.
29. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг өргөжүүлж, өрх бүрт хүртээмжтэй болгоно.
30. Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлж, телевизийн олон сувгийг орон даяар хүлээн авах боломжийг бүрдүүлнэ.
31. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрийн үйлчилгээнд бүрэн шилжүүлнэ.

Гурав. Хүн ам, нийгмийн бодлого

3.1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны бодлого

3.1.1. Бүх нийтийн боловсролыг хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунцсан бүтээлч, чадамжтай хүний нөөцийг нэмэгдүүлнэ.

- Бичиг үсэгт тайлагдалтын түвшинг ахиулна.
- Баг бүрт гэр цэцэрлэг байгуулах, хувилбарт сургалтын төрөл хэлбэрийг олшруулах замаар сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 2012 он гэхэд 70 хувьд хүргэнэ.
- ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, боловсролын хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

- ЕБС-ийг мэргэжлийн багшаар бүрэн хангаж, мэргэшлийг дээшлүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг сурах бичгээр төрөөс хангана.
- Үдийн цай хөтөлбөрийг Үдийн хоол болгон өргөжүүлнэ.
- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг шинэ техник технологи бүхий орчин үеийн лабораториор бэхжүүлж, суралцагчдын тоог 3 дахин нэмэгдүүлнэ.
- Дээд боловсролын чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, эмч, хөдөө аж ахуйн мэргэжлээр суралцагчдын хувийн жинг нэмэгдүүлнэ.
- Гадаадын өндөр хөгжилтэй оронд суралцагчдын тоог 3 дахин нэмэгдүүлнэ.
- Их сургуулийн хотхон байгуулна. Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн сургалтын бааз, лабораторийг сайжруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, оюутнуудын дотуур байрыг бүрэн тохижуулна.
- Их, дээд сургуулийн багшийг чадваржуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Оюутны сурлагын амжилтыг харгалзан сургалтын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, тэтгэлэг олгох, нийтийн тээврээр үйлчлүүлэхэд хөнгөлөлт үзүүлэх зэргээр оюутны сурч боловсроход төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- Хичээлийн болон дотуур байр, номын сан, спорт заалыг барих, өргөтгөх, сургуулийг компьютержүүлэх, интернэтэд холбох зэргээр чанартай боловсролын орчин бүрдүүлэхэд ахиц өөрчлөлт гаргана.

3.1.2. Монголын соёл, иргэншлийн дэвшилтэт ололт, үнэт зүйлсийг уламжлал, шинэчлэлийн ухаалаг зөв харьцаанд хадгалан хамгаалах, бататган хөгжүүлэх замаар үндэснийхээ соёлын дэлхийн соёлд эзлэх байр суурийг бэхжүүлнэ.

- Соёл урлагийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, “Соёл урлагийг 2099-2012 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” болосвруулж хэрэгжүүлнэ.
- Соёлын өвийг хөгжүүлэх тогтолцоог төгөлдөржүүлэх, музейн чанартай үйлчилгээг иргэдэд хүргэх таатай орчныг бүрдүүлнэ.
- Сумын соёлын төвийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг баяжуулж тогтмолжуулах, соёлын төвүүдийн барилгыг шинэчилж, засварлах, хөгжмийн зэмсэг, ном, тоног төхөөрөмжөөр хангах замаар хүүхэд, залуус, хн амд хүргэх соёлын үйлчилгэний нийгмийн нүр өгөөжийг дээшлүүлнэ.
- Мэргэжлийн урлагийн байгууллагын шилдэг уран бүтээлийг хөдөөгийн иргэдэд хүргэх соёлын үйлчилгээг төрөөс дэмжиж, хөдөө орон нутгийн хүн амд хүргэх соёлын үйлчилгээний нийгмийн үр өгөөжийг дээшлүүлнэ.
- Мэргэжлийн урлагийн байгууллагын шилдэг уран бүтээлийг хөдөөгийн иргэдэд хүргэх үйлчилгээг төрөөс дэмжиж, хөдөө орон нутгийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээг өргөжүүлнэ.

- Үндэсний номын ордны шинэ цогцолборыг барина. Сумын номын сангийн фондыг жил бүр баяжуулж, уншигчдын тоог нэмэгдүүлнэ.
- Монгол улсын түүх судлалыг хөгжүүлж, сурталчилгааг өргөжүүлнэ.

3.1.3. Шинжлэх ухаан, технологийн чадавхийг бэхжүүлж, үндэсний инновацийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын технологийн шинэчлэлийг дотоодын судалгаа боловсруулалтын ажлын үр дүн болон гадаадын дэвшилтэт технологийн ололтыг нутагшуулахтай хослуулах замаар хэрэгжүүлэх бодлого явуулна.

- Шинжлэх ухаан, технологийг тэргүүлэх чиглэл болгон эрчимтэй хөгжүүлэх бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- Зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангахуйц судалгаа, боловсруулалтын өрсөлдөх чадвартай хувийн хэвшлийг бий болгож, эрдэм шинжилгээний ажилтан, залу эрдэмтдийг бодлогоор дэмжинэ.
- Үндэсний инноваци, бүтээмжийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлж, эдийн засаг, нийгмийн шинэчлэлд оруулах хувь нэмрийг дээшлүүлнэ.

3.2. Эрүүл мэндийн бодлого

1. Хүн ам, ялангуяа өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох арга хэлбэрийг боловсронгуй болгож, санхүүжилтийн хэмжээг тасралтгүй нэмэгдүүлэх замаар өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээг өргөжүүлнэ.
2. Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэн гарах гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, хордлого, гэнэтийн аюул ослын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг боловсронгуй болгож, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах нөөц, чадавхийг бэхжүүлнэ.
3. Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах өнөөгийн тогтолцоог бэхжүүлж, аймаг, дүүргийн түвшинд өргөжүүлнэ.
4. Цахим эмнэлгийн сүлжээ, алсын зайн оношилгоо, эмчилгээг өргөжүүлэн, анагаах ухааны орчин үеийн ололт амжилтад тулгуурласан төрөлжсөн мэргэжлийн төвүүдийг хөгжүүлж, өвчнийг эрт оношлох, эмчлэх чадавхийг дээшлүүлнэ.
5. Яаралтай тусламжийн тогтолцоог шинэчлэн, түргэн тусламжийн үндэсний сүлжээ байгуулж, хөдөө орон нутаг, алслагдсан хүн амд үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулна.

6. **“Эрүүл эхээс эрүүл хүүхэд”** зарчмыг тусламж үйлчилгээний бүх шатлалд хэрэгжүүлж, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг тууштай бууруулна.
7. Ахмад настан, хөгжлийн бэршээлтэй иргэдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд нийцэхүйц эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
8. Эм, эмийн түүхий эдийг шинжлэх лабораторийн чадавхийг сайжруулах замаар эмийн чанарын баталгаажилтыг ханган, аюулгүй байдлыг дээшлүүлж, зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.
9. Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог шинэчилж, эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааг бие даалган, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжтэй нягт уялдуулан хөгжүүлнэ.
10. Эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэн, цалин, урамшууллыг нэмэгдүүлнэ.
11. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлж, практик үр өгөөжийг дээшлүүлнэ.
12. Нийтийн биеийн тамир хөгжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг дэмжиж, хүн амыг чийрэгжүүлнэ.
13. БЗДХ, ХДХВ-ийн халдвар, ДОХ-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ХДХВ-ийн халдвар, ДОХ-ын одоогийн бага тархалтыг өнөөгийн түвшинд тогтоон барина.

3.3. Хөдөлмөрийн зах зээлийн бодлого

1. Хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоог иж бүрнээр хөгжүүлж, боловсон хүчнийг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сургаж бэлтгэх, дадлагажуулах тогтолцоог бий болгоно.
2. Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого баримтална.
3. Хүн ам зүйн насны бүтцэд гарч байгаа өөрчлөлттэй уялдуулан хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
4. Албан бус секторыг албан ёсны хүрээнд оруулахад чиглэсэн санхүү, татвар, мөнгө зээл, бүртгэл, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын зэрэг олон төрлийн арга хэрэгслэлийг ашиглан, албан бус секторын хүрээг багасгана.

5. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрх бүрийн хэрэгцээтэй уялдуулж, өрхийн нэгээс доошгүй хүнийг ажилтай болгох замаар жилд 60,0 мянгаас дээш тооны ажлын байрыг бий болгоно.
6. МСҮТ-үүдээс гадна аж ахуйн нэгж, байгууллагууд, үйлдвэрийн газрыг түшиглэсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх олон талын арга хэлбэрүүдийг хөгжүүлж, ажил мэргэжлийн зөрүүтэй байдлын улмаас ажилгүйдэх шалтгааныг бууруулна.
7. Хөдөлмөрийн чадвар бүхий, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа иргэддээ зориулан нийтдээ 210.0 мянгаас доошгүй ажлын байрыг шинээр бий болгож, ажилгүйдлийг бууруулахад чиглэгдсэн олон талын арга хэмжээг хэрэгжүүлснээр 2012 оны эцэст ажилгүйдлийн түвшинг 2,5 хувьд хүргэж бууруулна.
8. Хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн ур чадварыг мэргэжлийн сургалтаар эзэмшүүлж, мэргэжилтэй ажилчид бэлтгэх, хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийг дэмжих нэгдсэн зохион байгуулалт бий болгох замаар тэдгээрт суралцагчдын тоог 3 дахин нэмэгдүүлнэ.
9. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрх бүрийн хэрэгцээтэй уялдуулж, өрхийн нэгээс доошгүй хүнийг ажилтай болгох замаар жилд 60,0 мянгаас дээш тооны ажлын байрыг барилга, дэд бүтцийн салбарт бий болгоно.

3.4. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар

1. Хүн ам зүйн насны бүтцэд гарч байгаа өөрчлөлттэй уялдуулан хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ
2. Үндэсний ажиллах хүчний ур чадварыг нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн бэлтгэх мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ тогтолцоог бий болгоно.
3. Бүрэн хөдөлмөр эрхлэлт, өндөр бүтээмжтэй хөдөлмөр, зохистой ажлын байраар хангах, ажилгүйчүүдэд мэргэшил, ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, иргэдийн идэвхи санаачилгыг дэмжих, бизнес эрхлэх орчин нөхцлийг бүрдүүлэхэд ядуурлыг бууруулах бодлогыг чиглүүлнэ.
4. Малчдын хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, аж ахуйгаа тогтвортой эрхлэх, өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн эдийн засаг, нийгмийн үйлчилгээг өргөжүүлж, албан секторт шилжихэд нь дэмжлэг үзүүлнэ.
5. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

6. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрх бүрийн хэрэгцээтэй уялдуулж, өрхийн нэгээс доошгүй хүнийг ажилтай болгох замаар жилд 60,0 мянгаас доошгүй тооны ажлын байрыг бий болгоно.
7. Ажилгүйдлийг бууруулахад чиглэгдсэн олон талын арга хэмжээг хэрэгжүүлснээр 2012 эцэст хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 65 хувьд хүргэнэ.
8. Хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцсэн ур чадварыг мэргэжлийн сургалтаар эзэмшүүлж, мэргэжилтэй ажилчид бэлтгэх, хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийг дэмжих нэгдсэн зохион байгуулалт бий болгох замаар тэдгээрт суралцагчдын тоог 3 дахин нэмэгдүүлнэ.
9. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд элсэгч, суралцагчдын тоог нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх сургалтын төвүүдэд ажил мэргэжил олгох тогтолцоог урамшуулан дэмжинэ.
10. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг хүнд хөдөлмөрөөс хөндийрүүлэх, эцэг эхийг нь ажлын байраар хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
11. Хөдөлмөрийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх замаар цалин хөлсний бүтээмжийн өсөлт амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.
12. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангасан ажлын байраар хангах, үйлдвэрлэлийн орчныг сайжруулахад чиглэсэн тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдлыг бууруулна.
13. Ажлын байран дээрх сургалтыг өртгөтгөж, гадаадаас авч буй ажиллах хүчний тоог бууруулна.

3.5. Ядуурал, нийгмийн хамгааллын бодлого

1. Нийгмийн хамгааллын бодлого нь улс орны нийт иргэдийн эрх ашигт нийцсэн байх ба тусгайлсан хөтөлбөр арга хэмжээг зорилтот бүлэгт оновчтой хүргэх аргазүй, зохион байгуулалтыг сайжруулна.
2. Халамжийн үйлчилгээний зохион байгуулалт менежментийг сайжруулан хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах бодлого баримтална.
3. Хүн амын насны бүтцэд гарч буй өөрчлөлтийг угтсан бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
4. Нийгмийн даатгалын тогтолцоог нийгэм-эдийн засгийн орчин болон ард иргэдийн хүлээлттэй уялдуулан өөрчлөн зохион байгуулах.
5. Нийгмийн даатгалын сангийн менежментийг боловсронгуй болгон зах зээлийн жишигт нийцүүлэн хөгжүүлнэ.
6. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох эрхзүйн орчинг шинэчилнэ.

7. Иргэд болон өрхийн бүртгэлийг сайжруулж амьжиргааны түвшний талаарх нэгдсэн мэдээллийн сантай болгоно
8. Ядуурлыг тодорхойлох аргачлал, нэгдсэн мэдээллийн сан бий болгож 50.000-аас доошгүй ядуу айл өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.
9. Гэр бүл бат бэх байх, уламжлалт ёс заншлаа хүндлэх, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, үр хүүхэд аюулгүй орчинд эрүүл өсөж хөгжих, авьяасаа хөгжүүлэх, сурч боловсрох эрмэлзэлтэй, бүтээлч, хариуцлагатай, хувь заяандаа эзэн иргэн болж төлөвших нөхцлийг бүрдүүлнэ.
10. Эцэг, эх, үр хүүхдээ эрүүл саруул өсгөн бойжуулж, боловсрол, хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгох хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхийг дэмжинэ. Төрөлтийг дэмжиж, хүн амаа өсгөх бодлого баримтална
11. Хүүхэд, гэр бүл, түүнтэй дүйцэх орчинд өсч торних, зөв хүмүүжил, ёс суртахуунтай болгоход чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
12. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг амьжиргааны түвшний өөрчлөлт, хэрэглээний үнийн индекс тэй уялдуулан нэмэгдүүлэх
13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг хүндэтгэсэн нийгмийн орчинг бүрдүүлж, тэдгээр иргэдийг нийгмийн амьдралд бусад иргэдийн адил эрх тэгш оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэхийг зорино.
14. Хүүхэд, залуучуудад эрүүл амьдралын зөв дадлыг олгох, аливаа хорт болон муу дадал, зуршлаас ангид байлгах, сэтгэлгээний хувьд эрүүл саруул байх, тодорхой зорилго, тэмүүлэлтэй амьдрах хүмүүжил олгохыг зорилго болгож энэ чиглэлээр гэр бүл, боловсролын болон олон нийтийн байгууллага, хамт олон аж ахуйн нэгж, байгууллагатай нягт хамтран ажиллаж, тэдний санаачилгыг дэмжин ажиллана.
15. Асран халамжлах хүнгүй, бүтэн өнчин, хараа хяналтгүй хүүхдийг төрийн анхаарал халамжид авч эрхийг нь хамгаалах үйлчилгээгээр хангана.
16. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд эмэгтэйчүүдэд зориулсан үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийнхэнтэй хамтран хүргэхдээ стандартын дагуу мэргэжлийн түвшинд хүргэн дэмжлэг үзүүлж ажиллана.
17. Гадаад оронд амьдарч буй монгол улсын иргэд, тэдний хүүхдүүдэд зориулсан эрх зүй, өмгөөллийн үйлчилгээг төсөл хөтөлбөрийн шугамаар бий болгон хөгжүүлнэ.
18. Хөвгүүд, охидын боловсролын ялгаатай байдлыг арилгаж, боловсролын салбарт адил тэгш хамрагдах орчин нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

3.6. Хүн ам зүйн бодлого

1. Гэр бүл бат бэх байх, уламжлалт ёс заншлаа хүндлэх, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, үр хүүхэд аюулгүй орчинд эрүүл өсөж хөгжих, авъяасаа хөгжүүлэх, сурч боловсрох эрмэлзэлтэй, бүтээлч, хариуцлагатай, хувь заяандаа эзэн иргэн болж төлөвших нөхцөлийг бүрдүүлнэ.
2. Эцэг, эх үр хүүхдээ эрүүл, саруул өсгөн бойжуулж, боловсрол, хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхийг дэмжинэ. Төрөлтийг дэмжиж, хүн амаа өсгөх бодлого баримтална.
3. Хүүхэд зургаан нас хүртэл гэр бүл, түүнтэй дүйцэх орчинд өсч торних, зөв хүмүүжил, ёс суртахуунтай болгоход чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
4. Ахмад настны тэтгэврийг ажилтан, албан хаагчдын цалингийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ.
5. Хөдөлмөрийн чадвар бүхий ахмадуудад тохирсон ажлын байр бий болгоход тусламж, дэмжлэг үзүүлнэ.
6. Ахмад настнуудын эрүүл мэндийг сайжруулахад зориулан эмнэлэг сувилал, ахмадын ордон байгуулна.
7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг хүндэтгэсэн нийгмийн орчинг бүрдүүлж, тэдгээр иргэдийг нийгмийн амьдралд бусад иргэдийн адил эрх тэгш оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэхийг зорино.
8. Мэргэжилгүй залуучуудыг тодорхой ажил мэргэжил эзэмших боломж нөхцөлөөр хангах замаар залуучуудын ажилгүйдлийг бууруулна.
9. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд элсэгч, суралцагчдын тоог нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын дэргэдэх сургалтын төвүүдэд ажил мэргэжил олгох тогтолцоог урамшуулан дэмжинэ.
10. Хүүхэд, залуучуудад эрүүл амьдралын зөв дадлыг олгох, аливаа хорт зуршил, муу дадлаас ангид байлгах, сэтгэлгээний хувьд эрүүл саруул байх, тодорхой зорилго, тэмүүлэлтэй амьдрах хүмүүжил олгохыг зорилго болгож энэ чиглэлээр гэр бүл, боловсролын болон олон нийтийн байгууллага, хамт олон аж ахуйн нэгж, байгууллагатай нягт хамтран ажиллаж, тэдний санаачлагыг дэмжинэ.
11. Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын хүүхдийн эрхийн Конвенцийг Монгол улсад бүрэн хэрэгжүүлж, мөрдүүлнэ.
12. Асран халамжлах хүнгүй, бүтэн болон хагас өнчин, хараа хяналтгүй орхигдсон хүүхдийг төрийн байгууллагын анхаарал, халамжид авахын хамт

хүүхдийн эрхийг зөрчиж байгаа байгууллага, хуулийн этгээд, иргэд, эцэг эхэд хариуцлага тооцож, хүүхдийн эрхийн зөрчлийг арилгана.

13. Хүүхдийн сурч боловсрох орчин нөхцлийг бүрдүүлэхийн хамт, сургууль завсардалтыг бууруулж, Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод тусгагдсан зорилтын тухайн үе шатны зорилтыг хангана.
14. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд төрөөс байнгын анхаарал, хяналт тавьж ажиллана.
15. Хүүхдийг дамлан худалдах, албадан хөдөлмөр хийлгэх, бэлгийн мөлжлөг болон бусад хууль бус үйл ажиллагаанд ашиглах, аюултай нөхцөлд ажиллуулах зэрэг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгана.
16. Хүүхдийн хөдөлмөрийг устгах асуудлаар олон нийтийн ойлголтыг төлөвшүүлэх, орон нутгийн тогтвортой үйл ажиллагааг дэмжинэ.
17. Хүүхдийн асуудлаархи бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад тэдний санаа бодол, хөгжиж байгаа авъяас чадварыг заавал харгалзан хүүхдийн бодитой оролцоог дэмжинэ.
18. Гадаад оронд оршин сууж байгаа Монгол Улсын харъяат хүүхдийг сурч боловсрох, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахын төлөө тухайн улс орны Засгийн газар, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.
19. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хувь хүн, нийгмийн гишүүний хувьд өөрийн сонголт, үзэл бодол, үнэт зүйлстэй байх, нийгмийн амьдралд оролцох оролцоог хөхиүлэн дэмжих, орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
20. Жендэрийн тэгш байдлыг гэр бүл, эдийн засаг, нийгэм, улс төр, соёл, хүний эрхийн хүрээнд хангах бодлого хэрэгжүүлнэ.
21. Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийг боловсруулан гаргах, ЖТБ-ыг хангах үндэсний тогтолцоо, хүний нөөц, чадавхийг бэхжүүлэн, бүх нийтэд жендерийн боловсрол олгох, жендерийн статистик мэдээллийн гаргадаг болно.

Дөрөв. Байгаль орчин, аялал жуулчлал, бүс нутгийн бодлого

Экосистемийн тэнцвэрт байдлыг хангахуйц байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх цогц бодлогыг хэрэгжүүлэн хөгжлийн тогтвортой орчинг бий болгох.

1. Байгалийн тэтгэх даац, чадавхийн хүрээнд нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, экологид халгүй цэвэр технологийг дэмжих бодлогыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд баталгаажуулна.

2. Түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, нүүрсийг боловсруулах, гэр хорооллыг орон сууцжуулахад зориулж инженерийн байгууламжийг өргөтгөх, ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, нийтийн тээврийг шинэчилж хийн түлшинд шилжүүлэх замаар Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулна.
3. Төв, суурин газрын хог хаягдлын менежментийг сайжруулж орчны бохирдлыг багасгана.
4. Усны талаархи төрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, гол мөрний урсцад тохируулга хийх, хуримтлагдсан усны нөөцийг шилжүүлэн ашиглах дэд бүтцийг байгуулж эхлүүлнэ.
5. Алтны шороон болон бага нөөцтэй орд, ой, усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүсэд ашигт малтмал олборлохыг хориглох, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халтай арга технологиор уул уурхай үйлдвэрлэл явуулахыг бүрэн зогсооно.
6. Монгол орны экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ.
7. Цөлжиж буй бүсэд унаган ургамлыг тарималжуулах, хур тунадас нэмэгдүүлэх, усыг хуримтлуулж хиймэл нуур цөөрөм байгуулж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг сааруулна.
8. Ойгоос бэлтгэх модны хэмжээг хязгаарлаж, мод орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, модны хэрэглээг импортоор хангах санаачилгыг дэмжин ойн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлнэ.
9. Амьтан, ургамлын нөөцийн хамгаалах, зохистой ашиглах менежментийг сайжруулж, тэдгээрийн байгалийн жамаар өсөж үржих, нөхөн сэргэх таатай нөхцөлийг бүрдүүлнэ.
10. Газар, түүний хэвлийн баялгийг зохистой ашиглах нэгдсэн бодлого хэрэгжүүлэн, газрын нэгдсэн үнэлгээний аргачиллыг шинэчлэн тогтоож мөрдүүлнэ.
11. Байгаль орчны төрийн хяналтын нэгдсэн удирдлагыг бүрдүүлж, байгалийн нөөц баялгийн халдашгүй байдлыг хангах үүрэг хариуцлагыг өндөржүүлнэ.
12. Аялал жуулчлалын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, жуулчлалын бүсүүдийн дэд бүтцийг сайжруулах замаар жилд 1.0 саяас доошгүй жуулчин хүлээн авах нөхцөлийг бүрдүүлнэ.
13. Хүн амын дотоодын шилжилт хөдөлгөөнийг зүй зохистой бодлогоор зохицуулж, бүсийн болон тэдгээрийн тулгуур төв, дагуул хотуудын төлөвлөлт, удирдлагыг сайжруулан, дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана.
14. “Хөдөөгийн хөгжил” үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ.

15. Бүсүүдэд үйлдвэрлэл, технологийн парк байгуулж ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгож, аж үйлдвэр, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.
16. Бүсийн тулгуур төв, аймгийн төв, уул уурхайн томоохон үйлдвэрийг түшиглэн эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариаланд суурилсан фермерийн аж ахуйг хөгжүүлнэ.
17. Улаанбаатарын бүсэд дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, харьцангуй өндөр, шинэ технологид суурилсан үйлчилгээ, оюуны багтаамжтай бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлнэ.
18. Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур зэрэг суурин газруудад эхэлсэн эдийн засгийн болон худалдааны чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
19. Эдийн засгийн чөлөөт бүс, аж үйлдвэрийн парк хөгжүүлэхэд Засгийн газрын зүгээс дэд бүтэц, эрчим хүчний асуудлыг шийдвэрлэх замаар дэмжлэг үзүүлнэ.
20. Сум бүрт 50.0 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй “Сум хөгжүүлэх сан” байгуулж ашиглана.
21. Алслагдсан болон говийн бүсийн нэмэгдэл олгох оновчтой хэлбэрийг бий болгоно.
22. Малчин бүрийг тэтгэврийн нэрийн данстай болгож, эрүүл мэндийн даатгалд хамруулна.
23. Малчид гар утас ашиглах, харилцаа холбоогоор шуурхай хангагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

Тав. Эрх зүй, засаглалын хөгжлийн зорилт

5.1. Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн төлөв байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан тодорхойлж, хийдэл, давхардал, зөрчлийг арилгах замаар хуулийг боловсронгуй болгож, засаг захиргааны дээд төв, орон нутгийн байгууллагаас гаргадаг эрх зүйн хэм хэмжээ тогтоосон дэд акт /дүрэм, журам, заавар зэрэг/-ыг цэгцлэн цөөрүүлнэ. Энэ зорилтын хүрээнд:

- 5.1.1. Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжид эрх зүйн болон мэргэжлийн үүднээс төлөв байдлын шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж, давхардсан, зөрчилдсөн заалтыг ангилан ялгаж, хуулийн хийдлийг арилгах ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.
- 5.1.2. Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар тэдгээртэй адилтгах норматив актыг

бүхэлд нь судалж, хуульд нийцээгүй актыг хүчингүй болгох арга хэмжээ авна.

- 5.1.3. Хууль зүйн үндэсний төвийн бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг төгөлдөршүүлж, хүний нөөц, техник хангамжийг нь сайжруулан, үйл ажиллагааны чанар үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
- 5.1.4. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.
- 5.1.5. [Хууль хэрэгжүүлэх, батлагдсан хууль тогтоомж, эрх зүйн бусад актыг төв орон нутагт цаг алдалгүй хүргэх](#), албан бус сургалтыг мэргэжлийн үндсэн дээр зохион байгуулах ажлын цар хүрээ, хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.
- 5.1.6. Харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- 5.1.7. Харьяа агентлаг, байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, амьдрах орчин, нийгмийн асуудлыг дээшлүүлэх цогц арга хэмжээ авна.
- 5.1.8. Харьяа агентлаг, байгууллагын алба хаагчдын мэргэжил, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн тусгай хөтөлбөр боловсруулж, сургалтын материаллаг баазыг сайжруулах арга хэмжээ авна.

Хууль зүйн сургуулиудад мэргэжлийн боловсролын стандартыг нэг мөр хэвшүүлж, сургалтын чанар, багшлах боловсон хүчин, орчны стандартыг шинэ шатанд гаргана.

5.1.9. Архивын баримтын ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, лавлагаа мэдээллийн ажлыг хөгжингүй орнуудын стандарт, жишигт хүргэж, архив, төрийн албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлнэ.

5.2. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, иргэдийн аюулгүй орчинд тайван амьдрах баталгааг хангахад чиглэсэн цогц арга хэмжээ авна. Энэ зорилтын хүрээнд:

- 5.2.1. [Цагдаагийн байгууллагын нэг алба хаагчийн үйлчлэх хүн амын тоог олон улсын жишигт ойртуулах арга хэмжээ авна.](#)
- 5.2.2. Цагдаагийн байгууллагын техник, хэрэгслийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн үе шаттайгаар шинэчлэн сайжруулна.
- 5.2.3. Замын хөдөлгөөнд хяналт тавих телекамерийн хяналтын системийг Улаанбаатар хотод бий болгоно.

- 5.2.4. Иргэдэд цагдаагийн ажил, үйлчилгээг ойртуулах зорилгоор байнгын пост (кобон систем) барьж байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 5.2.5. Гэмт хэргийн ул мөр, эд мөрийн баримтад дэвшилтэт технологи бүхий лабораторийн техник, арга хэрэгслийг ашиглан бусдын нөлөөнөөс ангид, хараат бус байдлаар шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэн зөв дүгнэлт гаргах нөхцлийг бүрдүүлнэ.
- 5.2.6. Террорист үйл ажиллагаа, хар тамхи мансууруулах бодис худалдах, олж авах, хэрэглэх, садар самуунд уруу татах, хил дамнуулан хүн наймаалах зэрэг шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудалд түлхүү анхаарч, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийг цагдаагийн байгууллагын бүтцэд бий болгож, зориулалтын тусгай хэрэгслээр хангана.
- 5.2.7. Иргэдийг төрийн хууль ёсыг хүндэтгэдэг, нийгмийн дэг журмыг сахин биелүүлдэг, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг ойлгон дэмждэг соёлд сургахад чиглэсэн арга хэмжээг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 5.2.8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудыг жигд татан оролцуулахад түлхүү анхаарч, тэдгээрийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд онцгойлон анхаарна.
- 5.2.9. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, улс, аймаг, сумын санд төрөөс жил бүр санхүүгийн дэмжлэг үзүүлж, мал хамгаалах малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхижүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.
- 5.2.10 Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, архидан согтуурах явдлын хор хөнөөлийг бууруулах ажлыг идэвхижүүлж, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх, хяналт тавих ажлыг шинэ шатанд гаргаж, архинд донтох өвчтэй хүмүүсийг эмчлэх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- 5.2.11. “Хүн байхын учир” аяныг улсын хэмжээнд жил бүр тодорхой зорилт, үе шаттайгаар зохион байгуулна.
- 5.2.12. Гадаад оронд ажиллаж, амьдарч буй Монгол Улсын иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зарим орон (БНХАУ-ын Бээжин, Эрээн хот, ОХУ-ын Москва, Улаан-Үд хот, БНСУ-ын Сөүл хот)-д суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад цагдаагийн асуудал эрхэлсэн дипломат ажилтан ажиллуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.

5.3. Монгол Улсын хил хамгаалалтад орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог баталгаажуулна. Энэ зорилтын хүрээнд:

- 5.3.1. Улсын хилийн бүсчилсэн (уулын, Увсын, ой тайгын, говь цөлийн, тал хээрийн хэсгийн) хамгаалалтын тогтолцоог бүрдүүлнэ.
- 5.3.2. Улсын хилийг “хугацаат цэргийн алба хаагч”-аар хамгаалуулдаг одоогийн тогтолцоог өөрчилж, хил хамгаалах албыг удирдан зохион байгуулах үүргийг мэргэжлийн байгууллага гүйцэтгэдэг, улсын хилийг хамгаалах үүргийг “мэргэшсэн гэрээт хилчин” гүйцэтгэдэг тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ.
- 5.3.3. Хил хамгаалах байгууллагын холбоо, мэдээллийн тогтолцоог шинэчилж, сансрын холбооны бие даасан сүлжээ бий болгоно.
- 5.3.4. Хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг хөрш орнуудын жишигт хүргэж, хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 5.3.5. Хил хамгаалалтын техник хангамж, зэвсэглэлийг шинэчлэх цогц арга хэмжээ авна.
- 5.3.6. Хилийн боомтод болон хилийн зурвас, бүсэд олныг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон, зорчигч, тээврийн хэрэгслийг барьцаалсан зэрэг онцгой нөхцөл үүссэн үед сөрөг тусгай ажиллагаа явуулах тусгай томилгоот салбар, нэгжийг байгуулж, зориулалтын тусгай хэрэгслээр хангана.
- 5.3.7. Монгол Улс -БНХАУ-ын хоорондын хилийн “Буйр нуур”-ын хэсэгт усан хилийн тэмдэглэл хийж, усан хил хамгаалалтыг илүү боловсронгуй болгоно.
- 5.3.8. Хөрш орнуудын хилийн асуудлаарх хамтын ажиллагааг өргөжүүлж, хилийн дэглэмийн асуудлыг шуурхай зохицуулах үүрэг бүхий хилийн албан ёсны төлөөлөгчийг БНХАУ-ын Хөх хотод ажиллуулах асуудлыг судалж, шийдвэрлэнэ.

5.4. Хорих ялын төрөл дэглэмийг нээлттэй ба хаалттай тогтолцоонд шилжүүлж, ялтныг нийгэмшүүлэх бодлогод эрс өөрчлөлт гаргана. Энэ зорилтын хүрээнд:

- 5.4.1. Хорих ангийн төрөл дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх асуудлыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж, хоригдогсдыг хуульд заасан шаардлага, олон улсын стандарт жишигт нийцсэн нөхцөлд байлгах боломжоор хангана.
- 5.4.2. Ялтныг нийгэмшүүлэх ажилд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх боломж, нөхцлийг бүрдүүлнэ.
- 5.4.3. Хорих анги болон цагдан хорих байрны харуул хамгаалалтыг орчин үеийн инженерийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана.

5.5. Эрх зүйн бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болгож, улсын бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагуудаас үзүүлж буй төрийн үйлчилгээг шинэ түвшинд хүргэнэ. Энэ зорилтын хүрээнд:

5.5.1. Улсын бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагууд (ИБМУТ, ЭХЭУБГ, ТЕГ-ын УБА)-ыг нэгтгэн зохион байгуулах замаар эрх зүйн бүртгэл (иргэн, хуулийн этгээд, үл хөдлөх эд хөрөнгө)-ийг нэг цэгт хийх нөхцөл боломжийг бүрдүүлж, бүртгэл мэдээллийн ажлыг цахим хэлбэрт шилжүүлнэ. – [Цахим нэг цонхны үйлчилгээ](#)

5.5.2. Иргэний биеийн өгөгдөл болон бусад төрлийн мэдээллийг агуулсан “Иргэний ухаалаг үнэмлэх” хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.6. Гадаадын иргэдийн бүртгэл, зөвшөөрөл, хяналтыг боловсронгуй болгох зорилгоор Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг олон улсын жишигт нийцүүлэх цогц арга хэмжээ авна. Энэ зорилтын хүрээнд:

5.6.1. “Иргэний бүртгэл-паспорт хяналтын нэгдсэн сүлжээ” төслийн хүрээнд хилийн бүх боомтыг холбох арга хэмжээ авна.

5.6.2. Хилийн боомтод ажиллаж байгаа Цагдаагийн Ерөнхий газар, Хил хамгаалах Ерөнхий газар, Гаалийн Ерөнхий газар, Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхэлсэн алба, Улсын мэргэжлийн хяналтын байгууллагын алба хаагчдын хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тэдгээрийг нэгдсэн ажлын байр, орон сууцаар хангах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

5.6.3. Улаанбаатар хот, Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуур боомтуудад стандартад нийцсэн [“Түр саатуулах байр” барина](#).

5.6.4. Харъяатын асуудал эрхлэх албаны эрх зүйн байдлыг дээшлүүлж, олон улсын жишигт (Цагаачлалын байгууллагын статустайгаар) хүргэнэ.

5.6.5. Мэргэжлийн хяналтын чадавхийг бэхжүүлж, хяналт шалгалтын ажлын үр нөлөөг дээшлүүлнэ.

5.6.6. Мэргэжлийн хяналтын байгууллагын хэтийн хөгжлийн бодлого чиглэлийг нарийвчлан тодорхойлж, Төрийн хяналт шалгалтын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгож мөрдүүлнэ.

5.6.7. Мэргэжлийн хяналтын байгууллагуудыг орчин үеийн техник, технологи бүхий лабораторитой болгож, материаллаг баазыг бэхжүүлж, боловсон хүчний чадавхийг сайжруулна.

5.6.8. Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.

5.7. Төрийн албыг бэхжүүлэх, иргэний нийгмийн оролцоог хангах, засаг захиргааны нэгжийн шинэчлэл, нутгийн удирдлагын бодлого

5.7.1. Олон нийтийн мэдээллийн эрх чөлөөг хангах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

5.7.2. Төрийн албыг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүргэх чадвартай болгон шинэчлэнэ.

5.7.3. Төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны уялдааг зохистой хангасан, цомхон чадварлаг, хариуцлагатай төрийн албаны тогтолцоог бүрдүүлнэ.

5.7.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталж, төрийн албанд хууль дээдлэх, авилгыг үл тэвчих ухамсар, соёлыг хэвшүүлнэ.

5.7.5. Хяналт –шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлнэ.

5.7.6. Засаг –захиргааны нэгжүүдийг эдийн засгийн хувьд бие даан хөгжих бололцоогоор хангана.

5.7.7. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож, эрх мэдлийн зохистой харьцааг тогтоон, нутгийн өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар нь төлөвшүүлэн хөгжүүлнэ.

Зургаа. Аюулгүй байдал, батлан хамгаалах, гадаад бодлогын зорилт

6.1. Бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх талаарх бодлого

6.1.1. Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, олон улс, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлнэ.

6.1.2. Зэвсэгт хүчний НҮБ-ын энхийн ажиллагаанд оролцох чадавхийг нэмэгдүүлэх стратегийн хүрээнд хоёр ангийг орон тооны бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, техникээр бүрэн хангаж, гурав дахь анги, “Цэргийн цагдаа”-ийн салбарыг байгуулан, НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаан дахь Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлнэ.

6.1.3. Зэвсэгт хүчний “Сургалтын нэгдсэн төв”-ийг “Энхийг сахиулах ажиллагааны олон улсын сургалтын төв” болгон өргөжүүлж, бүс нутгийн хэмжээний сургалт, дадлага явуулах нөхцлийг бүрдүүлнэ.

6.2. Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бэхжүүлэх бодлого

6.2.1. Батлан хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

6.2.2. Батлан хамгаалах нөөцийн удирдлага, зохицуулалтын бодлогыг сайжруулж, батлан хамгаалах төсвийн бүтцийг олон улсын жишигт ойртуулна.

6.2.3. Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

6.2.4. Цэрэг-стратегийн бэлтгэл сургалтын тогтолцоог үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцүүлэн боловсронгуй болгоно.

6.2.5. Монгол Улсын иргэдэд эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэхэд чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, идэвхитэй хамтран ажиллана.

6.2.6. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг орон нутагт бэлтгэх тогтолцоог төгөлдөржүүлж, бүсийн төвүүдэд байршилтай Зэвсэгт хүчний анги, салбарыг түшиглэн бүсийн сургалтын төвүүдийг үе шаттайгаар байгуулна.

6.2.7. Экологийн сүйрлээс сэрэмжлэн хамгаалах, ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх зэрэг ажил үүрэг биелүүлэхэд цэргийн дүйцүүлэх албаны оролцоог нэмэгдүүлэх, энэ ажилд цэргийн зарим салбарыг томилгоожуулах замаар дэмжлэг үзүүлнэ.

6.3. “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, Зэвсэгт хүчнийг олон талт үүрэг гүйцэтгэх чадавхитай, мэргэжлийн чиг хандлагатай болгон хөгжүүлэх бодлого

6.3.1. Зэвсэгт хүчний мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгон Ерөнхий зориулалтын, Хилийн болон Дотоодын цэргийн харилцан ажиллагааг нэгтгэн удирдах мэргэжлийн нэгдмэл удирдлагын тогтолцоог бүрдүүлнэ.

6.3.2. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, олон талт үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлнэ.

6.3.3. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа болон террорист үйлдлийн хор уршиг, хохирлыг арилгахад оролцох үүрэг бүхий тусгай томилгоот анги, салбар, нэгжийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэг, техникийг сайжруулж, хөдөлгөөнт чадварыг нь нэмэгдүүлнэ.

6.3.4. Зэвсэглэл, техникийг шинэчлэх дунд, урт хугацааны бодлогыг тодорхойлж, зэвсэглэл, техникийг шинэчлэн сайжруулах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.

6.3.5. Иргэн, цэргийн нисэхийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар агаарын довтолгооноос хамгаалах цэргийн техникийн шинэчлэлийг эхлүүлнэ.

6.3.6. Цэргийн албан хаагчдын амьдралын чанарыг сайжруулах, нийгмийн хамгааллын хүрээг өргөжүүлэх, офицер, ахлагч, тэтгэвэр чөлөөнд байгаа ахмадууд, тэдний гэр бүлийхнийг эмнэлэг, амралт, сувиллаар үйлчлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.3.7. Цэргийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр, төсөлд төрөөс санхүүгийн дэмжлэгтэйгээр хамруулах арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлэх, цэргийн амралт, сувилал, худалдаа, үйлчилгээний татваргүй сүлжээг

нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар тэдэнд үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулна.

6.3.8. ТЕГ-ын үндсэн чиг үүрэгт нийцүүлэн эрх зүйн орчин, зохион байгуулалтыг оновчтой болгох, хүний нөөцийг бэхжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

6.3.9. Бүртгэл, мэдээллийн тогтолцоог төгөлдөршүүлэх зорилт, мэдээлэл, харилцааны технологийн хөгжилтэй уялдуулан гүйцэтгэх ажлын болон холбооны техникийн шинэчлэлийг гүнзгийрүүлнэ.

6.3.10. Төв байрны цогцолбор, орон нутгийн зарим салбар, нэгжийн албаны байрыг барьж, тус байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжийг өргөтгөнө.

6.4. Гадаад бодлогын зорилт

6.4.1. Нээлттэй олон тулгуурт улс төр, эдийн засгийн дипломат гадаад бодлогын хүрээнд ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн түншлэлийн, АНУ, Япон, Европын холбоотой иж бүрэн түншлэлийн харилцааг, бусад улс орнуудтай тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлнэ.

6.4.2. НҮБ болон олон улсын бусад байгууллагын хүрээнд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэр хүнд, байр суурийг улам бэхжүүлэн баталгаажуулах үйл ажиллагаа явуулж, ардчилсан институциуд, сайн засаглал, төрийн байгуулалт, чадавхийг цаашид боловсронгуй болгох, эдийн засгийн хөгжлийг хурдасгахад чиглэсэн, тодорхой зорилготой тусламж дэмжлэг авах бодлого хэрэгжүүлнэ.

6.4.3. Бүс нутгийн улс төр, эдийн засгийн харилцаанд оновчтой оролцох, Ази Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага АПЕК-д элсэх чиглэлээр ажиллана.

6.4.4. Монгол Улсын гадаад харилцааг эдийн засагжуулах чиглэлээр түлхүү анхаарч далайд гарцгүй орны эрх ашгийг хамгаалсан бодлогыг тууштай явуулах, түүний дотор ОХУ, БНХАУ-ын нутаг дэвсгэр дээгүүр монголын бараа бүтээгдэхүүн, ачааг дамжин өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлэх, бүс нутгийн орнуудтай авто зам, төмөр зам, өндөр хүчдэлийн шугам, холбоо зэрэг дэд бүтцийн төслүүдийг эхлүүлж, хилийн боомтын байршлыг оновчтой тогтоож, байнгын ажиллагаатай болгоход анхаарч ажиллана.

6.4.5. Гадаад орнуудын бодит сонирхлыг Монгол Улсад бий болгох, улс орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг үр ашигтай болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, уул уурхайн болон томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалтыг зохистой харьцаагаар оруулах бодлого баримтална.

6.4.6. Үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг гаалийн тарифын болон бусад хориг хязгаарлалтгүйгээр, хөнгөлөлттэй нөхцөлөөр экспортлох бүс нутаг, орны тоог нэмэгдүүлэн хүнс, газрын тосны бүтээгдэхүүний хангамж болон

аюулгүй байдлыг олон улсын гэрээ, хэлэлцээрээр зохицуулах арга хэмжээ авна.

6.4.7. Хилийн чанад дахь иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, монгол иргэдэд туслах сан байгуулан, консулын албыг өргөжүүлэн бэхжүүлнэ.

6.4.8. Монгол орныг гадаад ертөнцөд сурталчлан таниулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулна.

----- о О о -----